



ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 99

Хэрлэн сум

Батширээт сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ажлын албаны мэргэжилтний сул орон тоонд
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад /64/ оноо авч, тэнцсэн Гансүрэнгийн Бат-Эгшиглэнг Батширээт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Г.Бат-Эгшиглэнг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Батширээт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Л.Хоролмаа)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Батширээт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

